Бараа материалын үлдэгдэл урьд оноос 28519.0 мянган төгрөг буюу 12.3 хувиар өссөн нь төсвийн байгууллагууд Ковид-19 цар тахалтай холбоотой эм боох материал, тусгай зориулалтын материал, бусад хангамжийн материалын дансанд эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн материал авч нөөцөлсөн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 5. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1,023.3	1,404.8	381.5	0.54
Засаг даргын Тамгын газар	33,547.5	29,300.2	(4,247.3)	11.27
Сургууль	104,424.6	99,528.7	(4,895.9)	38.29
Цэцэрлэг	43,353.6	48,797.9	5,444.3	18.77
Эрүүл мэндийн төв	34,906.3	65,192.2	30,285.9	25.08
Соёлын төв	14,173.4	15,723.9	1,550.5	6.05
НИЙТ ДҮН	231,428.7	259,947.7	28,519.0	100.00

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 333226.5 мянган төгрөгийн бараа материалын 305586.5 мянган төгрөг нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан, 24245.6 төгрөгийн материал хандиваар, 3394.5 мянган төгрөгийн материал шилжүүлэн авсан байна.

Хүснэгт № 6. Бараа материалын орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	333,226.5	Хасагдсан	304,707.5
Худалдан авсан	305,586.5	Худалдсан, зарцуулсан	296,460.4
Хандиваар	24,245.6	Шилжүүлсэн	0.0
Шилжүүлэн авсан	3,394.5	Бусад	8,247.2

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4724215.1 мянга, эцсийн үлдэгдэл 5161118.9 мянган төгрөг болж, 436903.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БИЕТ ХӨРӨНГӨ	4653503.1	5090606.9	437,103.8	98.6
Барилга байгууламж, орон сууц	3,338,691.5	3,672,691.5	334,000.0	71.2
Тээврийн хэрэгсэл	325,274.8	293,774.8	-31,500.0	5.7
Машин тоног төхөөрөмж	482,622.5	555,369.4	72,746.9	10.8
Тавилга эд хогшил	253,264.3	289,094.5	35,830.2	5.6
Дуусаагүй барилга байгууламж	23,770.0	20,000.0	-3,770.0	0.4
Номын фонд	19,290.0	22,386.8	3,096.8	0.4
Бусад үндсэн хөрөнгө	210,589.9	237,289.9	26,700.0	4.6
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	70,712.0	70,512.0	-200.0	1.4
Программ хангамж	2,470.0	2,270.0	-200.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	68,242.0	68,242.0	0.0	1.3
НИЙТ ДҮН	4,724,215.1	5,161,118.9	436,903.8	100.0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 436903.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс Гурванбулаг сумын сургуулийн 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн спорт заалны дээврийн 45000.0 мянган төгрөгийн засвар, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хичээлийн байрны 280000.0 мянган төгрөгийн засварыг тайлант онд сайжруулалтаар бүртгэсэн, машин тоног тоног төхөөрөмжийн дансанд төсвийн хөрөнгөөр 35737.9 мянга, үнэ төлбөргүй 37008.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэснийг бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	11,491.1	13,190.1	1,699.0	0.26
Засаг даргын Тамгын газар	1,841,127.5	1,884,188.0	43,060.5	36.51
Сургууль	1,209,734.0	1,580,061.7	370,327.7	30.61
Цэцэрлэг	945,290.5	953,119.0	7,828.5	18.47
Эрүүл мэндийн төв	638,641.5	623,741.5	(14,900.0)	12.09
Соёлын төв	77,930.5	106,818.6	28,888.1	2.07
НИЙТ ДҮН	4,724,215.1	5,161,118.9	436,903.8	100.0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд сургууль 354741.5 мянга, соёлын төв 25384.1 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар, дээд шатны байгууллага болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 38339.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авсан ба сургууль 9000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс хооронд шилжүүлж бүртгэн тайлант онд нийт 31700.0 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгийг акталсан байна.

Хүснэгт № 9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл /мянган төгрөг/

Нэмэгдсэн	481,373.82	Хасагдсан	44,470.00
Худалдан авсан	53,908.70	Худалдсан	0.00
Хандиваар	380,125.62	Акталсан	31,700.00
Шилжүүлэн авсан	38,339.50	Шилжүүлсэн	12,770.00
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	9,000.00	Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	0.00

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 13172.1 мянга, эцсийн үлдэгдэл 3737.9 мянган төгрөг болж 9434.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	5,243.6	3,859.9	(1,383.7)	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	4,057.6	-	(4,057.6)	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-	-	-
Байгууллагад төлөх өглөг	900.7	3,770.8	2,870.1	97.7
Хувь хүмүүст төлөх өглөг	285.2	89.1	(196.1)	2.3
Дүн	5,243.6	3,859.9	(1,383.7)	100.0

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 3770.8 мянган төгрөгийн төлөх, 89.1 мянган төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг байгаа ба Эрүүл мэндийн төвийн 1963.6 мянга, Соёлын төвийн 1783.1 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг байгаа нь гол нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт № 11. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	188.9	-	(188.90)	-
Засаг даргын Тамгын газар	157.2	-	(157.18)	-
Сургууль	2,161.2	28.1	(2,133.10)	0.73
Цэцэрлэг	1,121.8	-	(1,121.76)	-
Эрүүл мэндийн төв	1,458.0	1,963.6	505.62	50.87
Соёлын төв	156.5	1,868.1	1,711.67	48.40
НИЙТ ДҮН	5,243.6	3,859.9	(1,383.7)	100.0

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4335318.2 мянга, эцсийн үлдэгдэл 4660883.4 мянган төгрөг болж, 325565.3 мянган төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 12. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,852,532.3	1,852,532.3	-	39.75
Өмч: - төрийн	1,852,532.3	1,852,532.3	-	39.75
Хуримтлагдсан үр дүн	1,888,962.6	2,214,527.9	325,565.3	47.51
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	593,823.2	593,823.2	-	12.74
Дүн	4335318.2	4660883.4	325565.3	100.00

Эх сурвалж: Гурванбулаг сумын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4660883.4 мянган төгрөг болж 325565.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн хуримтлагдсан үр дүнгийн 325565.3 мянган төгрөгийн өөрчлөлттэй холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2019.12.16-ны өдрийн хуралдаанаар 13/03 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 51300.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3500.0 мянга, нийт 54800.0 мянган төгрөгөөр анх баталсан ба 2020.10.30-ны өдрийн 1/07 дугаар тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 5500.0 мянган төгрөгөөр нэмж тодотгон татварын орлогыг 57300.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3000.0 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт №13. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	57,300.0	151,116.0	93,816.0	163.7
1.1.ИОТХ	8,000.0	26,320.5	18,320.5	229.0
1.2. Хадгаламжийн хүүгийн орлого	33,000.0	40,577.2	7,577.2	23.0
1.3. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	-	1,000.0	1,000.0	
1.4.Бууны татвар	4,000.0	2,130.0	(1,870.0)	(46.8)
1.5.Улсын тэмдэгтийн хураамж	1,500.0	1,497.4	(2.6)	(0.2)
1.6. Газрын төлбөр	1,800.0	5,204.0	3,404.0	189.1
1.7.Ан агнуур	-	64,000.0	64,000.0	
1.8.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	8,000.0	9,392.9	1,392.9	17.4
1.9. ТТАМАТөлбөр	1,000.0	989.0	(11.0)	(1.1)
1.10. Нохойны татвар	-	5.0	5.0	
2.Татварын бус орлого	3,000.0	6,800.0	3,800.0	126.7
2.1.Хүү торгуулийн орлого	3,000.0	6,800.0	3,800.0	126.7
Нийт дүн	60,300.0	157,916.0	97,616.0	161.9

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 93816.0 мянга, хүү торгуулийн орлогыг 3800.0 мянга, нийт 97616.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Харин бууны татвар, улсын тэмдэгтийн хураамж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого тасарсан байгаа тул цаашид орлогын төлөвлөгөөг бүх нэр төрлөөр биелүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Сумын ИТХ-ын 2019.12.16-ны өдрийн хуралдаанаар 13/03 дугаар тогтоолоор сумын Засаг даргын Тамгын газрын өөрийн орлогыг нийт 1000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 754.0 мянган төгрөгийн орлого оруулсныг тайланд бүртгэжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн төлөлтөөр тайлант онд 95388.0 мянган төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 55988.9 мянган төгрөгийн орлогыг оруулсан бол ОНХС-д өвс тэжээл, малын ашиг долооцын орлогоор 729.3 мянган төгрөг орсныг орлогоор бүртгэж тайлагнасан байна

3.5.11 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2315999.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2173217.7 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 2104085.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 69132.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын /орон нутгийн / төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны төсөв батлах тухай 2019.11.29-ний өдрийн 18/16 дугаар тогтоолд зааснаар Гурванбулаг сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 2900.0 мянга, аймгийн төсөвт 97800.0 мянга, нийт 100700.0 мянган төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 115160.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 114.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №14. Улс, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А. Улсын төсөв	2900.0	2965.0	65.0	102.2
1. ААНБ-ын орлогын татвар	900.0	1038.4	138.4	115.4
2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1400.0	857.5	-542.5	61.3
3. Агаарын бохирдол /авто/	600.0	1069.1	469.1	178.2
В.Аймгийн төсөв /712/	97800.0	112195.5	14395.5	114.7
1. ЦТХА орлого /Суутган -1/	90000.0	103654.8	13654.8	115.2
2. АТӨЯХ-ийн татвар	4500.0	4701.9	201.9	104.5
3. ҮХЭХ-ийн татвар	600.0	866.1	266.1	144.4
4. Газрын төлбөр	2700.0	2972.7	272.7	110.1
Нийт дүн	100700.0	115160.5	14460.5	114.4

Төсвийн төлөвлөлт

Аймгийн СТСХ-ээс авсан судалгаагаар тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 5 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Эрүүл мэндийн төв төсвийн төслийг хүргүүлээгүй ба сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019.12.16-ний өдрийн 13/03 дугаар тогтоолоор нийт 2306121.0 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт №15. Төсвийн төлөвлөлт байгууллагаар /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	84,274.2	70,963.2	(13,311.0)
Засаг даргын Тамгын газар	455,592.5	373,987.5	(81,605.0)
Сургууль	973,072.4	829,945.9	(143,126.5)
Цэцэрлэг	431,889.7	293,209.3	(138,680.4)
Эрүүл мэндийн төв		397,859.1	397,859.1
Соёлын төв	129,236.5	100,393.8	(28,842.7)
Сум хөгжүүлэх сан		147,452.0	147,452.0
Орон нутгийн хөгжлийн сан		92,310.2	92,310.2
Нийт дүн	2,074,065.2	2,306,121.0	232,055.8

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2019.12.13-ний өдрийн 14/23 дугаар тогтоолоор анх баталсан 2303121.0 мянган төгрөгийг 2020.10.30-ны өдрийн 1/07 дугаар тогтоолоор 30017.3 мянган төгрөгөөр бууруулж баталсан бол тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зардлыг аймгийн Засаг даргын 2020.11.27-ний өдрийн А/770 дүгээр захирамжаар 63424.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2020.12.31-ний өдрийн А/850 дугаар захирамжаар 32506.1 мянган төгрөгөөр бууруулснаар сумын нийт төсөв 2315999.0 мянган төгрөг болжээ.

Нийт зардлын 1391674.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 22185.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 80366.9 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 552297.4 мянган төгрөгийг аймгийн төсвөөс сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс, 60300.0 мянган төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 96388.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 112787.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн авч, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 16119.0 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 4836.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Гурванбулаг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №16. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөг/

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	397976.9	394809.7	3167.2	99.2
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	74618.1	73425.4	1192.7	98.4
Ерөнхий боловсролын сургууль	845839.9	825659.8	20180.1	97.6
Цэцэрлэг	273385.5	252420.0	20965.5	92.3
Эрүүл мэндийн төв	397859.1	392995.5	4863.6	98.8
Соёлын төв	92394.7	91725.3	669.4	99.3
Орон нутгийн хөгжлийн сан	86472.8	69132.1	17340.7	79.9
Сум хөгжүүлэх сан	147452.0	73050.0	74402.0	49.5
Нийт дүн	2315999.0	2173217.8	142781.2	93.8

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2173217.7 мянган төгрөг буюу 93.8 хувьтай байгаа нь цэцэрлэгийн урсгал зардлыг 20965.5 мянга, ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 20136.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэж сум хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг 74402.0 мянган төгрөгөөр дутуу олгосон нь голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 17. Гурванбулаг сумын Засаг даргын төсвийн гүйцэтгэл, хөтөлбөрөөр /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,315,999.00	2,173,217.76	142,781.24	93.84
70105 ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	74,618.10	73,425.38	1,192.72	98.40
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	60,525.90	59,407.14	1,118.76	98.15
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	900.00	890.00	10.00	98.89
80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал	13,192.20	13,128.24	63.96	99.52
70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	397,976.90	394,809.68	3,167.22	99.20
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	257,186.60	255,451.13	1,735.47	99.33
80106 Баг, хорооны ҮАЗардал	71,014.10	68,793.70	2,220.40	96.87
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	11,680.20	11,680.16	0.04	100.00
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	51,034.40	51,824.80	(790.40)	101.55
82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах	7,061.60	7,059.89	1.71	99.98
70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	86,472.80	69,132.10	17,340.70	79.95
80904 Нийгмийн зориулалттай барилга	86,472.80	69,132.10	17,340.70	79.95
71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	397,859.10	392,995.51	4,863.59	98.78
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	21,137.80	21,131.24	6.56	99.97
80302 Нэг иргэнд ногдох нормативаар	14,614.20	15,217.00	(602.80)	104.12
81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлч	362,107.10	356,647.27	5,459.83	98.49
71702 Соёл урлаг	92,394.70	91,725.29	669.41	99.28
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	90,110.90	90,110.69	0.21	100.00
80214 Уран бүтээл хийлгэх	1,983.80	1,314.60	669.20	66.27
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	300.00	300.00	-	100.00
71801 Сургуулийн өмнөх боловсрол	273,385.50	252,419.99	20,965.51	92.33
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	10,748.70	9,396.87	1,351.83	87.42
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	21,101.30	19,576.02	1,525.28	92.77
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	83.70	83.70	-	100.00
81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	16,991.90	16,991.55	0.35	100.00
81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	1,660.30	1,660.30	-	100.00
81833 Явуулын багшийн үйлчилгээ	5,750.40	5,654.02	96.38	98.32
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	186,691.80	170,329.65	16,362.15	91.24
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	30,357.40	28,727.88	1,629.52	94.63
71802 Ерөнхий боловсрол	835,647.90	815,511.10	20,136.80	97.59
80103 Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	25,616.70	25,616.63	0.07	100.00
80109 ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	60,985.90	59,696.52	1,289.38	97.89
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,504.40	1,467.37	37.03	97.54
81801 үдийн цай хөтөлбөр	14,517.00	8,547.92	5,969.08	58.88
81806 Дотуур байрны үйлчилгээ	85,167.60	75,970.65	9,196.95	89.20
81834 Боловсролын стандарт, сургалтын үйл ажиллагаа	481,130.60	477,512.04	3,618.56	99.25
81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	166,725.70	166,699.97	25.73	99.98
71806 Насан туршийн болон албан бус боловсрол	10,192.00	10,148.71	43.29	99.58
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	10,192.00	10,148.71	43.29	99.58
72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	147,452.00	73,050.00	74,402.00	49.54
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	147,452.00	73,050.00	74,402.00	49.54

Эх сурвалж: :Гурванбулаг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 4 байгууллага 90791.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 2 байгууллага 31869.4 мянга, нийт 122660.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт 18. Нэмэлт санхүүжилтийн дансны судалгаа /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	ЗДТГ	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ	НИЙТ
НИЙТ ОРЛОГО	52,104.00	60,997.39	5,213.90	4,345.40	122,660.69
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,682.41	58,549.59	5,213.90	4,345.40	90,791.29
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,421.60	2,447.80	-	-	31,869.40
НИЙТ ЗАРЛАГА	36,622.62	60,997.29	5,213.90	4,345.00	107,178.81
Бараа, ажил үйлчилгээний зардал	36,622.62	10,241.80	-	4,345.00	51,209.42
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	33,911.12	-	-	33,911.12
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	11,629.37	5,213.90	-	16,843.27
Хөрөнгийн зардал	-	5,215.00	-	-	5,215.00
ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН	15,481.38	0.10	-	0.40	15,481.88

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 157 мэдээллээс 150 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 19. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	12	12	9	3	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан
2	Хагас жил	3	3	3	-	
3	Улирал бүр	2	8	7	1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг 1-р улиралд,
4	Сар бүр	5	60	52	8	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 4, 5, 6, 10-р сард, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1, 2-р сард, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг 1, 2-р сард
5	Тухай бүр	6	72	69	3	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 10, 11, 12-р сард
НИЙТ		30	155	140	15	

Эх сурвалж. Гурванбулаг сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 2200.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1400.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 22600.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 20. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	2200.0	1	2200.0			100.0
Албан шаардлага	1	1400.0	1	1400.0			100.0
Зөвлөмж	4	22600.0	4	22600.0			100.0
Нийт	6	26200.0	6	26200.0			100.0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс бүх байгууллага аудитад хамрагдсан ба 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж 3 санхүүгийн тайланд түүвэрт хамруулж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 2, “2” 4 /Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг/ дүгнэлт өгсөн байна.

Хүснэгт 21. Хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагууд

БАЙГУУЛЛАГЫН НЭР	ДҮГНЭЛТ ӨГСӨН ГОЛ АСУУДАЛ
"ХЯЗГААРЛАЛТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ"	
Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургууль	Тус байгууллагын спорт заалны шалны засварын ажлын худалдан авах ажиллагааг 2020 оны 09 дүгээр сард зарлан 12 дугаар сарын 10-нд "Хаст шонхор" ХХК-тай ажлыг 2020.12.20-ы дотор гүйцэтгүүлэхээр 23002.9 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлж ажлыг гүйцэтгээгүй байхад 2020.12.22-ны өдөр 21047.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож авлагаар тусгасан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй.
Гурванбулаг сумын эрүүл мэндийн төв	Үндсэн хөрөнгө бараа материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулгахад тайлант оны эцэст хөрөнгийн тооллогыг хийгээгүй. Бараа материалын нярвын тайлангийн орлого нягтлан бодох бүртгэлээс нийт дүнгээрээ 5564.1 мянган төгрөгөөр дутуу, зарлага 1687.8 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй тайлагнагдсан. Аймгийн ЭМГ-ын даргын 2020 оны А /38, А/48, А/ 168, А/174, А/133 тоот тушаалаар Эрүүл мэндийн байгууллагуудад цар тахалтай холбоотой үнэ төлбөргүй олгосон 6947,2 мянга, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хүрээнд олгогдсон 974.8 мянга, нийт 7922.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, шатахууныг орлогод аваагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлагналын "Үнэн зөв байдал", "Орших байх", "Иж бүрэн байх", "Үнэлгээ", "Хэмжилт" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 88092.1 мянган төгрөгийн 22 алдаа, зөрчил илэрснээс 24533.5 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 11979.7 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 33139.3 мянган төгрөгийн 10 зөрчилд менежментийн захидлаар удирдлагад зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, 18439.6 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд залруулжээ. /Хавсралт 2./

Гурван булаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 2 зөвлөмж өглөө. /Хавсралт 1./

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.1.1. **Илрүүлэлт:** Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн байгууллагууд ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, эд хөрөнгийн тооллого тооцоог бүрэн хийж, анхан шатны баримтыг бүрдүүлээгүйгээс 2 байгууллага “Хязгаарлалттай” дүгнэлт авсан нь сумын Төрийн сан гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалттай хэрэгжээгүй, санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүйтэй холбоотой байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт, Оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг тус тус зөрчсөн байна.

3.1.2. **Эрсдэл:** Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн материаллаг хэмжээний алдаа зөрчлийн дүн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлаас хэтэрсэн байх.

3.1.3 **Өгсөн зөвлөмж:** Сумын төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэл, анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв гаргаж байгаад болон эд хөрөнгийн тооллого тооцоог иж бүрэн хийж байгаа эсэхэд сумын Өмч хамгаалах зөвлөл, санхүүгийн албаны даргын хяналтыг сайжруулах.

3.1.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

3.2. УДИРДЛАГЫН ДЭЭД БОЛОН ДОТООД ХЯНАЛТ

3.2.2 Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтална” гэснийг зөрчсөн байна.

3.2.2 **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.

3.2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн, үнэн зөв байршуулж байгаад тавих хяналтыг хуулийн хугацаанд нь тавьж байх.

3.2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 25-ний дотор нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



Ж.ӨСӨХБАЯР 2021.03.25

А.ЦЭЭНЯМ 2021.03.25

Б.МӨНХБАТ 2021.03.25

5. Хавсралт 1.: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо 2020	Аудитын нэр:	Гурванбулаг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код: БНА-2021/1/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Гурванбулаг сумын Засаг дарга	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяаны төсвийн байгууллагууд ААНБ-д мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн, эд хөрөнгийн тооллого тооцоог бүрэн хийж, анхан шатны баримтыг бүрдүүлээгүйгээс 2 байгууллага "Хязгаарлалттай" дүгнэлт авсан байхад сумын санхүүгийн албаны дарга хяналт тавьж ажиллаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тогтожаргал
2	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	-	Зөвлөмж өгсөн.	Сумын Засаг дарга, санхүүгийн албаны дарга	Б.Гантулга, П.Тогтожаргал
ДҮН		-			

_____ оОо _____

6. Хавсралт 2.: Харьяа ТШЗ-ийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /мянган төгрөг/	Алдаа, зөрчлийн шийдвэрлэлт.	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
					Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5	6
1	Ерөнхий боловсролын сургууль	Сургуулийн захирал Д.Цэцэгэ нь 7 дугаар сард ээлжийн амралтаа биеэр эдлээгүй байхад 2300423 төгрөгийн ээлжийн амралтын цалин бодож олгосон, мөн сумын Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 177 дугаар захирамжаар 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал буюу 1447348 төгрөгийг давхардуулан олгосон байна.	1,447.3	Төлбөрийн акт тогтоосон	Захиал, нягтлан бодогч	Д.Цэцэгэ, Ж.Дорждагва
2	Ерөнхий боловсролын сургууль	Тайлант хугацаанд Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 131/ШШ2020/00848 тоот захирамж, аймгийн Засаг даргын 2020 оны А784 тоот захирамжийн дагуу сургуулийн захирал Д.Цэцэгэд ажилгүй байсан хугацааны цалин 4335.2 мянган төгрөг олгосон байна.	4,335.2	Албан шаардлага өгсөн	Захиал, нягтлан бодогч	Д.Цэцэгэ, Ж.Дорждагва
3	Ерөнхий боловсролын сургууль	Ажиллагсдын цалингийн санг 2020 оны 6, 7, 8, 12 дугаар саруудад нийт 2900.2 мянган төгрөгөөр Нийгмийн даатгалын хэлтэст дугуу мэдээлсэн.	2,900.2	Албан шаардлага өгсөн	Захиал, нягтлан бодогч	Д.Цэцэгэ, Ж.Дорждагва
4	Ерөнхий боловсролын сургууль	Тус байгууллагын спорт заалны шалны засварын ажлын худалдан авах ажиллагааг 2020 оны 09 дүгээр сард зарлан 12 дугаар сарын 10-нд "Хаст шонхор" ХХК-тай ажлыг 2020.12.20-ы дотор гүйцэтгүүлэхээр 23,002,900 төгрөгийн гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлж ажлыг гүйцэтгээгүй байхад 2020.12.22-ны өдөр 21,047,805 төгрөгийн санхүүжилт олгосон.	21,047.8	Төлбөрийн акт тогтоосон	Захиал, нягтлан бодогч	Д.Цэцэгэ, Ж.Дорждагва
5	Ерөнхий боловсролын сургууль	Байгууллагын дансанд 38006.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл байгаа ба тус авлагууд нь 2001-2002 онд нярааар ажиллаж байсан Ч.Батсүхтэй холбоотой 572.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	572.2	Албан шаардлага өгсөн	Захиал, нягтлан бодогч	Д.Цэцэгэ, Ж.Дорждагва
6	Ерөнхий боловсролын сургууль	"Дэвших болор" ХХК-тай сургалтын үйл ажиллагаанд ашиглах ухаалаг самбар худалдан авахаар 9885.0 мянган төгрөгийг шилжүүлж тухайн хөрөнгийг хүлээж аваагүй учраас авлагаар тусгасан байна.	9,885.0	Зөвлөмж өгсөн	Захиал, нягтлан бодогч	Д.Цэцэгэ, Ж.Дорждагва
7	Ерөнхий боловсролын сургууль	Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2020 онд нийт 151 мэдээлэл оруулахаас хагас жилээр болон тухай бүр оруулах төсөв, өмч хөрөнгө зарцуулах шийдвэр, батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ, тендерийн ерөнхий мэдээлэл, хагас жилийн санхүүгийн тайлан гэсэн 34640931 төгрөгийн 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	0.0	Зөвлөмж өгсөн	Захиал, нягтлан бодогч	Д.Цэцэгэ, Ж.Дорждагва
8	ЗДТГ	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч 12157.5 мянган төгрөгийн үнэ бүхий цахилгааны мотор биетээр байгаагүй	12,157.5	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрсайхан
9	ЗДТГ	Сум дундын Ойн анги тус байгууллагад 2020 онд нийт 31056.0 мянган төгрөгийн өвс тэжээл нийлүүлж 4172.0 мянган төгрөгийн авлагатай гарсан байхад тооцоо нийлээгүй, данс бүртгэлд тусгаагүй байна.	4,172.0	Албан шаардлага өгсөн	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрсайхан
10	ЗДТГ	Тайлант хугацаанд шилэн дансанд 27 төрлийн 151 мэдээлэл байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцруулж мэдээлсэн байна. 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мэдээлэлд нэмэлт санхүүжилтийн дансны 52104.0 мянган төгрөгийн санхүүжилтийг байршуулаагүй байна.	0.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрсайхан
11	ОНХС	Шилэн дансны мэдээлэл 86472.8 төгрөг дугуу мэдээлсэн	0.0	Зөвлөмж өгсөн	Дарга, нягтлан бодогч	Р.Гантулга, Б.Дэлгэрсайхан
12	Цэцэрлэг	Шилэн дансанд оруулсан мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан эсэхийг судалж үзэхэд нийт 151 төрлийн мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл байгаа бөгөөд 149 мэдээллээс сар бүр байршуулах 1 төрлийн 1 мэдээлэл, тухай бүр байршуулах 5 төрлийн 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0.0	Зөвлөмж өгсөн	Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Э.Цэрэнханд, Ж.Дорждагва
13	Цэцэрлэг	НДШ-ийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаас түүвэрлэн давтан тооцоолж ХХОАТ-ын болон НДШ-ийн тайлантай тулгахад тохирч байсан ба гүйцэтгэлийг ерөнхий журнал руу хөөн шалгахад 655.3 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг цалингийн зардалд хаасан	655.7	Санхүүгийн тайланд залруулсан	Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Э.Цэрэнханд, Ж.Дорждагва
14	Эрүүл мэндийн төв	Нийт дүнгээрээ бараа материалын няrvын тайлангийн орлого нягтлан бодох бүртгэлээс 5564.1 мянган төгрөгөөр дулуу, зарлага 1687.8 мянган төгрөгөөр илүү буюу нийтдээ 7251.9 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан	7,251.9	Санхүүгийн тайланд залруулсан	ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа
15	Эрүүл мэндийн төв	Тусламж хандивын орлогыг бүрэн тусгасан эсэхийг ЭМГ-аас ирүүлсэн мэдээлэлтэй тулган шалгахад ЭМГ-ын даргын 2020.01.08-ны өдрийн А/48 тоот, 2020.12.31-ний А/174 тоот, 2020.11.20-ний А/33 тоот, 2020.12.25-ны А/ 168 тоот, 2020.04.21-ний А /38 тоот тушаалуудаар хуваарилсан нийт 7922.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, шатахууныг орлогод аваагүй.	7,922.0	Санхүүгийн тайланд залруулсан	ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа

Гурванбулаг сумын Засаг даргын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

A	1	2	3	4	5	6
16	Эрүүл мэндийн төв	Үндсэн хөрөнгө бараа материалын дансны үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулгахад тооллогын бүртгэл байхгүй бөгөөд тус байгууллага нь тооллого хийгээгүй байна. Горим сорил гүйцэтгэх явцад 1580.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалд орлогдсон	1,580.0	Санхүүгийн тайланд залруулсан	ЭМГ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа
17	Эрүүл мэндийн төв	Өглөг, авлагын үлдэгдлийг Татварын хэлтэс, НДХ-тэй тооцоо хийж үзэхэд ХХОАТ-ын өмнөх онд илүү төлөөд авлагаар тусгаагүй 1816.0 мянган төгрөг, авто тээврийн хэрэгслийн татварын илүү төлөлт 124.6 мянган төгрөг, тайлант онд 28-31 дугаартай автомашины татварыг 3 удаа буюу 97.8 мянган төгрөгийг илүү төлж нийт 2038.4 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй	2,038.4	Төлбөрийн акт тогтоосон	ЭМГ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа
18	Эрүүл мэндийн төв	Тайлант хугацаанд 2019 онд худалдан авсан 8 нэрийн 5150.0 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл бодоогүй.	1,030.0	Санхүүгийн тайланд залруулсан	ЭМГ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа
19	Эрүүл мэндийн төв	Санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ данс 68918.6 мянган төгрөгөөр бүртгэлтэй байхад ҮХ-ийн дэлгэрэнгүй журналд 9178.6 мянган төгрөгөөр, ОНӨГ-ын нэгтгэл тайланд -7640.7 мянган төгрөгөөр тус тус тусгагдсан байна.	0.0	Зөвлөмж өгсөн	ЭМГ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа
20	Эрүүл мэндийн төв	Санхүүгийн тайланд тусгагдсанаар хүнсний 643.8 мянган төгрөгийн, эмийн 9180.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Эмийн үлдэгдэл оны эхэнд 1200.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9137.0 мянган төгрөг, аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй олгосон тендерийн эм 12960.8 мянган төгрөг буюу нийт орлого 22097.8 мянган төгрөг, үүнээс зарцуулсан нь 14117.3 мянган төгрөг, үлдэгдэл 9180.7 мянган төгрөг байгаа нь тухайн жилийн зарцуулсан төсөвтэй харьцуулж үзэхэд 8 орчим сарын хэрэглээний эм нөөцөлсөн байна.	9,180.7	Зөвлөмж өгсөн	ЭМГ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа
21	Эрүүл мэндийн төв	Тайлант оны эмийн батлагдсан төсөв 9041.9 мянган төгрөг, батлагдсан төсөвт багтаан эмийн худалдан авалтыг хийсэн байхад эмийн 1916.1 мянган төгрөгийн эмийн өртэй гарсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зөв зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн байна.	1,916.1	Зөвлөмж өгсөн	ЭМГ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа
22	Эрүүл мэндийн төв	Шилэн дансны сайтад сар, улирал, жил, тухай бүр оруулах нийт 29 төрлийн давхардсан тоогоор 151 мэдээллийг байршуулахаас 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна. Тайлант хугацаанд сар бүр байршуулах 3 төрлийн 5, тухай бүр байршуулах 5 төрлийн 14, бүтэн жилээр байршуулах 2 төрлийн 2, нийт 10 төрлийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	0.0	Зөвлөмж өгсөн	ЭМГ-ийн дарга, нягтлан бодогч	Г.Сүхбаатар, Д.Эрдэнэтуяа
Дүн			88,092.1			

oOo